



НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ

ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ДӨРӨВДҮГЭЭР ТАЙЛАН

2023 оны 08 дугаар сарын 15



Эх бэлдсэн:

М.Баянжаргал

(Хүний эрхийн зөрчил бууруулах асуудал хариуцсан мэргэжилтэн)

Боловсруулсан:

Д.Номинчимэг

(Хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах асуудал хариуцсан мэргэжилтэн)

Хянасан:

Б.Болорсайхан

(Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн Нарийн бичгийн дарга)

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА
НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ НЭГЖ

Хаяг: 116 тоот, Засгийн газрын II байр

Нэгдсэн Үндэстний гудамж 5/1, Чингэлтэй дүүрэг

Улаанбаатар 15160, Монгол Улс

Цахим шуудангийн хаяг: nchr@cabinet.gov.mn

2023 он 10 сар

ТАНИЛЦУУЛГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТӨЛӨВЛӨГӨӨГ

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

ХАРААТ БУС

ТАЙЛАГНАЛЫН

МЕХАНИЗМЫН ЗӨВЛӨМЖ

ЗОРИЛТЫН ҮНЭЛГЭЭ

СУРГАМЖ

ЗӨВЛӨМЖ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМГТГ — Ашигт малтмал, газрын тосны газар

АНУ — Америкийн Нэгдсэн Улс

БНСУ — Бүгд Найрамдах Солонгос Улс

БОАЖЯ — Байгаль орчин, аялал жуулчлалын яам

ГҮТББ — Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага

ИНБ — Иргэний нийгмийн байгууллага

МАСАМ — Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь төсөл

НЗТ — Нээлттэй Засгийн Түншлэл

НҮТББ — Нийтэд үйлчилдэг төрийн бус байгууллага

ОБЕГ — Онцгой байдлын ерөнхий газар

ОҮИТБС - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга

СаЯ — Сангийн яам

ТХЗ — Тогтвортой хөгжлийн зорилго

УИХ — Улсын Их Хурал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УУХҮЯ — Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ҮҮАТ — Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө

ХЗДХЯ - Хууль зүй, дотоод хэргийн яам

ЦХХХЯ — Цахим хөгжил, харилцаа холбооны яам

ЭМЯ — Эрүүл мэндийн яам

ҮСДИ - Үндэсний сайн дурын илтгэл

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс 2013 онд Нээлттэй Засгийн Түншлэлд нэгдсэнээс хойш Үндэсний үйл ажиллагааны I, II, III, IV төлөвлөгөөг (ҮҮАТ) тус тус хэрэгжүүлсэн билээ.

Анхдугаар ҮҮАТ (2014-2016) нь байгаль орчны мэдээллийг ил тод болгох, төсвийн ил тод байдал, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн,

удаах ҮҮАТ (2016-2018) 11-11 төвийн гар утасны аппликэйшн, шилэн дансны тогтолцоог сайжруулах, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгох эрх зүйн орчныг сайжруулах, уул уурхайн салбарт ашиг хүртэгч өмчлөлийн мэдээллийг ил тод болгоход чиглэсэн,

гуравдугаар ҮҮАТ (2018-2020/2019-2021) нь хог хаягдлын менежмент, олон улсын санхүүжилттэй төслүүдийн гэрээний ил тод байдалд анхаарахад чиглэсэн,

Дөрөвдүгээр ҮҮАТ (2021-2023) нь олборлох салбарын ил тод байдал, төрийн худалдан авалт, цахим засаглал, хог хаягдлын менежмент, төсвийн ил тод байдал, хэвлэлийн эрх чөлөө, хууль тогтооход олон нийттэй зөвлөлдөх механизм, эм, эмнэлгийн хэрэгслийн менежмент, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө зэрэг зорилт дэвшүүлжээ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

ҮҮАТ-ний хамтын бүтээлийн үйл явцад иргэний нийгмийн төлөөлөл идэвхтэй оролцжээ. Дөрөвдүгээр ҮҮАТ-д орох асуудлыг тодорхойлох цуврал уулзалтууд 2021 оны 01 дүгээр сард эхэлсэн бөгөөд дөрөвдүгээр ҮҮАТ-г боловсруулах оролцогч талуудын төлөөлөл бүхий хамтарсан Ажлын хэсгийг тус оны 09 дүгээр сард байгуулав.

Төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, улс төрийн намууд, олон улсын агентлагуудын 200 гаруй төлөөлөгч 2021 оны 06-11 дүгээр сарын хугацаанд 5 удаагийн хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд нийт 80 асуудлыг дэвшүүлж түүнээс нэн тэргүүний 9 үүрэг амлалтын агуулгыг гаргажээ.

Эдгээр амлалтыг манлайлж хариуцан хэрэгжүүлэх УУХҮЯ, ХЗДХЯ, СаЯ, ЭМЯ, ЦХХХЯ, иргэний нийгмийн түншлэгч 32 байгууллагатай хамтран 2021 оны 12 дугаар сард албан ёсоор баталсан дөрөвдүгээр ҮҮАТ-г хэрэгжүүлэхээр болов.

ХАРААТ БУС ТАЙЛАГНАЛЫН МЕХАНИЗМЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Үйл ажиллагааны үндэсний дөрөвдүгээр төлөвлөгөөнд иж бүрэн үнэлгээ хийж, 2022 оны 07 дугаар сард Хараат бус тайлагналын механизмаас дараах зөвлөмж гаргасан болно:

Зорилт 1: Эрдэс баялгийн салбарын ил тод байдал

- Сангийн яамыг оролцуулж байх;
- Хэрэв Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль батлагдахгүй тохиолдолд, нэмэлт өөрчлөлт хийж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Хүнд үйлдвэрлэлийн тухай хуулийн төсөл, Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд салбарын ил тод байдлын тухай зүйл заалт нэмэлтээр оруулах;
- Эрдэс баялгийн салбарын мэдээллийн үнэн зөвийг шалган баталгаажуулах механизмыг боловсруулах;
- Хууль сахиулах байгууллагууд нь тухайн мэдээллийн санг ашиглан санхүүгийн гэмт хэргийг олж тогтоох, мөрдөн шалгах, ялах боломжийг хангасан механизмыг хөгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн дагуу ажилласны үр дүнд зорилтод хүрэх 4 үе шат бүрэн хэрэгжиж, 2 үе шат ахиц дэвшил сул зэрэглэлд багтжээ.

ХАРААТ БУС ТАЙЛАГНАЛЫН МЕХАНИЗМЫН ЗӨВЛӨМЖ

Зорилт 2 болон 8: Мэдээллийн эрх чөлөө болон Хэвлэл мэдээллийн талаарх хууль тогтоомж

- Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтүүдэд хэрэгжилтийн механизмуудыг сайтар тусгаж өгөх;
- Хамаарах төрийн байгууллагуудын ажилтнуудыг сургах;
- Үүрэг амлалт 2 дээрх тодорхой зорилт тусгаагүй үйл ажиллагаануудыг, хамтын оролцоотойгоор, тэр дундаа иргэний нийгмийн талуудын оролцоотойгоор бодит үзүүлэлтүүдтэй болгон сайжруулах;
- Давхцаж байгаа ижил үйл ажиллагаануудыг цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд нэгтгэн нэг үүрэг амлалт болгох замаар төлөвлөгөөг боловсруулагч талуудын үйл ажиллагааны уялдаа зохицуулалт, хэрэгжилтийг зохистой байдлаар хангах.

Дээрх зөвлөмжийн дагуу ажилласны үр дүнд зорилтод хүрэх 9 үе шат бүрэн хэрэгжиж, 3 үе шат ахиц дэвшил сул зэрэглэд багтжээ.

ХАРААТ БУС ТАЙЛАГНАЛЫН МЕХАНИЗМЫН ЗӨВЛӨМЖ

Зорилт 3: Төрийн худалдан авах ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах

- Үүрэг амлалтын төлөвлөлт, хэрэгжилтэд иргэний нийгмийн түншлэгч талуудыг оролцуулах;
- Тендерийн үнэлгээ хийх үйл явцад иргэдээс гадна иргэдийн ажиллуулж байгаа иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах;
- Хэрэв тендерийн баримт бичгийг цаасан хэлбэрээр үргэлжлүүлэн хүлээн авах тохиолдолд Төрийн худалдан авах ажиллагааны газар нь зөвхөн сканердах бус харин нээлттэй өгөгдлийн форматаар машинд уншигдахуйцаар цахим хэлбэрт хөрвүүлж байх.

Дээрх зөвлөмжийн дагуу ажилласны үр дүнд зорилтод хүрэх 4 үе шат бүрэн хэрэгжиж, 2 үе шат ахиц дэвшил сул зэрэглэлд багтжээ.

ХАРААТ БУС ТАЙЛАГНАЛЫН МЕХАНИЗМЫН ЗӨВЛӨМЖ

Зорилт 4: Иргэний орон зайг хамгаалсан эрх зүйн орчныг бүрдүүлэх

- Оролцоот зөвлөлдөх үйл явцыг ханган баталгаажуулахын тулд Төрийн байгуулалтын байнгын хороо нь Холбооны эрх зүйн байдлын тухай хууль болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдэд агуулсан зүйл заалтуудын үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, үнэлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудыг хамруулсан нийтийн сонсгол зохион байгуулах шаардлагатай;
- Холбооны эрх зүйн байдлын тухай хууль болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдэд хийгдэх зорилтот нэмэлт өөрчлөлтүүдийг тодорхой болгох;
- Иргэний нийгмийн байгууллагуудын бүртгэлтэй холбоотой бүхий л мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох.

Дээрх зөвлөмжийн дагуу ажилласны үр дүнд зорилтод хүрэх 2 үе шат бүрэн хэрэгжиж, 2 үе шат ахиц дэвшил сул зэрэглэлд багтжээ.

ЗОРИЛТ

1 ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ

2 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАМААР ТӨРӨӨС МЭДЭЭЛЭЛ АВАХ ИРГЭДИЙН ЭРХИЙГ БАТАЛГААТАЙ ХАНГАЖ, ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ

3 ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД СҮҮЛИЙН ҮЕИЙН ДЭВШИЛТЭГ ТЕХНОЛОГИД ТУЛГУУРЛАН ХҮНИЙ ОРОЛЦООГ БАГАСГАХ, ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ

4 ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙ, ТӨЛӨВШИЛ, ЭВЛЭДЭН НЭГДЭХ ЭРХИЙГ ДЭМЖИЖ, ХАРААТ БУСААР БИЕ ДААН, ӨӨРИЙГӨӨ УДИРДАН ЯВУУЛАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛСЭН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

5 НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХӨНДЛӨНГИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ

6 УЛСЫН ТӨСӨВ, ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

7 ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ, ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ

8

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ
БҮРДҮҮЛЭХ


9

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛЖ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ

ЗОРИЛТЫН ҮНЭЛГЭЭ

ЗОРИЛТ-1 ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ

Хүрэх үе шат: Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг УИХ-ын 2021 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барьж, хэлэлцүүлэх



Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт		<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Үүл үүрхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар</u></p> <p>“Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн төсөл”-ийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль” болгон шинэчилсэн.</p> <p>Хуулийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлж санал авсан.</p> <p>Засгийн газрын хуралдаанд танилцуулахаас өмнө хэлэлцүүлэг хийхээр төлөвлөж байна.</p>
Төрийн бус байгууллагуудын санал		<p><u>1. Хил хязгааргүй алхам ТББ (2023.08.28):</u></p> <p>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн төслийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” хууль болгон шинэчилсэн.</p> <p>Хуулийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлж санал авсан.</p> <p>Засгийн газрын хуралдаанд танилцуулахаас өмнө аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид, орон нутгийн иргэд, захиргааны албан хаагчидтай хэлэлцүүлэг хийж, намрын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.</p> <p><u>2. Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.30):</u></p> <p>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг 2020 онд боловсруулсан боловч УИХ-д өргөн</p>

барих чиглэлээр хариуцан хэрэгжүүлэгч УУХҮЯ-ны зүгээс ямар нэг хүчин чармайлт гаргаагүй.

Иймд, авлигатай тэмцэх Засгийн газрын үйл ажиллагааны хүрээнд ХЗДХЯ хуулийн төслийг татан авч, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” хууль болгон шинэчилж, иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлж, санал авсан.

Засгийн газрын хуралдаанд танилцуулахаас өмнө хэлэлцүүлэг хийж, намрын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Цаашид амлалт хэрэгжүүлэхэд учирч байгаа саад, бэрхшээлийг шийдэхийн тулд хариуцагч этгээд буюу үүрэг хүлээгчийн хариуцлагыг тайланд тодорхой дурдахаас гадна үлдсэн хугацаанд юу хийсэн байх талаар дурдах саналтай байна.

ТББ-ын үнэлгээ		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээ өгсөн үндэслэл	Намрын чуулганаар Ашигт малтмалын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн баригдаж хэлэлцэгдэхээр бол “Ахиц дэвшил сайн” гэж үзээд “Ногоон” болгох боломжтой гэж үзэж байна.	
Хүрэх үе шат: Эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Үүл уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар</u></p> <p>Эрдэс баялгийн мэдээллийн сан үүсгэж, нээлттэй өгөгдлийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх хяналт тавих нийтлэг журам”, Монгол Улсын Ерөнхий сайдын “Шил” ажиллагааны хэрэгжилтийг хангах, ажлын хүрээнд эрдэс баялгийн салбарын нээлттэй мэдээллийг тус яамны цахим хуудаст сар бүр шинэчлэн байршуулж байна.</p>	
Төрийн байгууллагуудын санал	<p>1. <u>Хил хязгааргүй алхам ТББ (2023.08.28):</u></p> <p>Эрдэс баялгийн мэдээллийн сан үүсгэж, нээлттэй өгөгдлийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж,</p>	

нийтлэх, шинэчлэх хяналт тавих нийтлэг журам”, Монгол Улсын Ерөнхий сайдын “Шил” ажиллагааны хэрэгжилтийг хангах, ажлын хүрээнд эрдэс баялгийн салбарын зарим нээлттэй мэдээллийг тус яамны цахим хуудаст сар бүр шинэчлэн байршуулж байна.

2. Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.30):

ОУИТБС-ын хүрээнд Эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдэж, ОУИТБС-ын стандартад заасан мэдээллүүдийг нийтэд ил тод болгоод байна.


Цаашид энэхүү мэдээллийн сангийн мэдээллийг өргөтгөн, мэдээлэл нийлүүлэх төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой хуульчилж, хэвийн үйл ажиллагаа аюулгүй байдлыг хангах зардлыг төрөөс хариуцах асуудлыг хуульчлах шаардлага хэвээр байна.

Иймд, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь Олборлох салбарын ил тод байдлын тухай хуулийг батлах хэрэгцээг хангаж чадахгүй юм.

УУХҮЯ-ны цахим хуудаст зөвхөн эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл байдаг бөгөөд зөвхөн .pdf хэлбэрээр нийтлэгддэг.

Тиймээс УУХҮЯ-ны цахим хуудсаар дамжуулан салбарын мэдээллийг бүрэн нийтэлдэг гэж хэлэх боломжгүй.

АМГТГ-аас тусгай зөвшөөрлийн бүртгэл мэдээллийг нийтэлдэг боловч ОУИТБС-ын стандартыг бүрэн хангаагүй бөгөөд нээлттэй мэдээллийн стандартад нийцдэггүй.

ТББ-ын үнэлгээ		<i>Ахиц дэвшил сул</i>
<p>Үнэлгээ өгсөн үндэслэл</p>	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын мэдээллийн сан нь IV төлөвлөгөөнд тусгагдсан амлалт үүргээс өмнө 2008 онд байгуулагдаж, хэвийн үйл ажиллагааг хангах, шинэчлэн сайжруулах ажлууд Европын сэргээн босголт хөгжлийн банк, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж ирсэн.</p> <p>Энэхүү санг ажиллуулах хүрээнд УУХҮЯ ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээдэггүй буюу ОУИТБС-ын ажлын алба хариуцдаг.</p> <p>Мэдээллийн санг сайжруулах, үйл ажиллагааг нь хуульчлах талаар IV төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд ямар</p>	

нэг ахиц гараагүй, харин ч УУХҮЯ-ны дэмжлэг, оролцоо буурсан байна.

Хүрэх үе шат: Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн холбогдох байгууллага, төрийн өмчит компаниудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх; Одоо Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын тайлангаар дамжуулан нийтэд ил тод болгодог мэдээллүүдийг төрийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар дамжуулан шууд мэдээлдэг болох;

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
----------------	---	---

Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Үүл уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар</u></p> <p>2021 оны тайлангаар тэргүүлэх 64 компанийн мэдээллийг ил тод болгосон бөгөөд татвар төлбөр хураамжийн 15 нэрийн, орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар төлбөр хураамжийн 12 нэрийн орлого болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг ил тод болгож байна.</p> <p>ОҮИТБС-ын 2022 оны тайланг 90 орчим компанийн мэдээллээр 2023 онд багтаан ил тод болгохоор төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Мөн хүчин төгөлдөр байгаа хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, хүчингүй болгосон, шилжүүлсэн, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, шалгараагүй аж ахуйн нэрс, нүүрсний олборлолт, дотоод борлуулалт болон экспорт, уулын ажлын тайлан, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ногдол ашиг, нутгийн захиргааны байгууллагуудтай байгуулсан гэрээг ил тод болгож байна.</p>
------------------------	--

Төрийн бус байгууллагуудын санал	<p><u>1. Хил хязгааргүй алхам ТББ (2023.08.28):</u></p> <p>2021 оны тайлангаар тэргүүлэх 64 компанийн мэдээллийг ил тод болгосон бөгөөд татвар төлбөр хураамжийн 15 нэрийн, орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар төлбөр хураамжийн 12 нэрийн орлого болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг ил тод болгож байна. ОҮИТБС-ын 2022 оны тайланг 90 орчим компанийн мэдээллээр 2023 онд багтаан ил тод болгохоор төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Мөн хүчин төгөлдөр байгаа хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, хүчингүй болгосон, шилжүүлсэн, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл,</p>
----------------------------------	---

шалгараагүй аж ахуйн нэрс, нүүрсний олборлолт, дотоод борлуулалт болон экспорт, уулын ажлын тайлан, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ногдол ашиг, нутгийн захиргааны байгууллагуудтай байгуулсан гэрээг ил тод болгож байна.

Мөн олборлох үйлдвэрлэлийн төслийн байгаль орчин, нийгмийн мэдээллийг нээлттэй болгох маягтууд боловсруулан батлуулсан ч эрх зүйн хувьд баталгаажуулж байсаар байна.


Иймд, ОУИТБ-ыг хангах тухай хуулийн төсөлд холбогдох заалтууд тусгасан.

2. Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.30):

Гэхдээ ил тод байдлыг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагуудын үүрэг хуульчлагдаагүй, тайлан гаргаагүй компаниудад хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс сүүлийн жилүүдэд төрийн байгууллагуудын оролцоо суларч, тайлан гаргах компаниудын тоо буурч байна.

2019 онд ОУИТБС-ын стандартад орсон өөрчлөлтөөр төрийн өмчит компаниудын тайлагналд шинэ шаардлагууд тавих болсон ч хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

Санаачилгын хүрээнд төрөөс ил болгох мэдээллийг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хэвшүүлэн хэрэгжүүлэх буюу mainstreaming шаардлага бүрэн хэрэгжээгүй хэвээр байна.

ТББ-ын үнэлгээ		Ахиц дэвшил сул
<p>Үнэлгээ өгсөн үндэслэл</p>	<p>Холбогдох төрийн байгууллагууд ОУИТБС-ын тайланд зориулж тусад нь мэдээлэл тайлан гаргаж өгдөг ба тэр нь тухайн байгууллагаас нийтэд шууд мэдээлдэг өгөгдөлтэй зөрдгөөс гадна цаг хугацааны хувьд хоцорсон мэдээлэл байдаг.</p> <p>Энэ нь олон нийтийн эрдэс баялгийн салбарын талаар эргэлзээгүй, баталгаатай мэдээллийг нэг дороос, шуурхай авах боломжийг бууруулдаг.</p> <p>Иймд, нэгдсэн стандартаар төрийн байгууллагууд мэдээллээ тухай бүрд нь нийтэлж, түүнийг нь ОУИТБС-ын мэдээллийн санд холбох буюу mainstream шаардлагыг ОУИТБС-аас хэрэгжүүлэгч улс орнууд тавих болсон.</p>	

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль батлагдсанаар үүнийг хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Хүрэх үе шат: Мэдээллийн сангийн хэвийн, аюулгүй үйл ажиллагааг хангах техник, технологийн шийдлийг олж хэрэгжүүлэх

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
----------------	---	---

Үнэлгээг нотлох баримт

Хэрэгжүүлсэн байгууллага: Үүл үүрхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар

Мэдээллийн системүүдийн хэвийн, аюулгүй үйл ажиллагааг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

- Байгууллагын бүх хэрэглэгчийн компьютер болон серверүүдийн вирусийн эсрэг хамгаалалтад Kaspersky Endpoint Security for Windows программыг ашигладаг ба Kaspersky Security Center-нэгдсэн удирдлагын программаар нэг цэгээс хянадаг.
- Интернэт урсгал болон веб серверүүдийн хамгаалалтад Next generation Fire WALL (Palo-Alto) ашигладаг. Тухайн хамгаалалтын төхөөрөмжүүд нь HA (High Availability) горимд ажилладаг.
- Физик серверүүдийг хөргөлт болон тэжээлийн нөөцлүүртэй тусгайлан тохижуулсан өрөөнд байрлуулсан.
- Физик серверүүд CLUSTER горимоор ажилладаг ба сервер үйлдлийн системүүд виртуал технологид (VMware) бүрэн шилжсэн
- Физик серверүүд болон давхар бүрийн дотоод сүлжээний свитч, хяналтын камерууд 46 цаг тасралтгүй ажиллах тэжээлийн нөөцлүүрт холбогдсон.
- Мэдээллийн системийн нөөцлөлт өдөр бүр программаар хийгддэг.
- Байгууллагад ашиглагдаж байгаа бүх windows болон Server үйлдлийн системүүд, өгөгдлийн сангийн удирдлагын (SQL) программ, вирусийн эсрэг программ, сүлжээний хамгаалалтын төхөөрөмжүүд нь албан ёсны лицензтэй.
- Системийн аюулгүй үйл ажиллагааг хангах зорилгоор параллель серверийг болон нөөцлөлт давхар серверийг ажиллуулахаар төлөвлөсөн.

Төрийн бус байгууллагуудын санал

1. Нээлттэй нийгмийн форум ТББ (2023.08.30):

Эрдэс баялгийн салбарын мэдээллүүд УУХҮЯ болон АМГТГ, Геологийн газар, БОАЖЯ, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар гэх мэт төрийн олон байгууллагуудад байдаг боловч энэхүү үүрэг амлалтад


дурдсан мэдээллийн сан нь эдгээрийг нэгтгэсэн, бүрэн бөгөөд бүтэцлэгдсэн, нээлттэй мэдээллийн стандартад нийцсэн мэдээллийн сан юм.

Өөрөөр хэлбэл, энэхүү үүрэг амлалт нь үүнийг одоогийн ОУИТБС-ын мэдээллийн санд суурилан байгуулж, үйл ажиллагаа, зардлыг нь хуульчлах тухай юм.

Энэ асуудал хуульчлагдаагүйгээс мэдээлэл нийлүүлэх төрийн байгууллагуудын үүрэг оролцоо, хариуцлага суларсаар байгаагаас гадна ОУИТБС-тай холбоотой зардлыг өнөөг хүртэл зөвхөн олон улсын байгууллагуудын санхүүжилтээр шийдэж ирсэн нь цаашдын тогтвортой байдлыг эрсдэлд оруулж байгаа болно.

Харин тайлангийн энэ хэсэгт дурдсан мэдээлэл нь зөвхөн АМГТГ-ын мэдээллийн сангийн техникийн шийдлийн тухай мэдээлэл байна.

Иймд, эрдэс баялгийн салбарын нэгтгэсэн мэдээллийн сангийн аюулгүй байдлын техникийн шийдэлтэй холбоотой мэдээллийг ОУИТБС-ын Ажлын албанаас авах нь зүйтэй.

ТББ-ын үнэлгээ		Үнэлгээ өгөөгүй
Үнэлгээ өгсөн үндэслэл	ОУИТБС-ын ажлын албанаас мэдээлэл авсны дараа үнэлгээ өгөх.	
Хүрэх үе шат: Ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөвт суулган шийдвэрлэх		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Үул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар</u></p> <p>2023 оны улсын төсөвт 367 сая төгрөгийг батлуулсан. 2024 онд Улсын төсөвт 773,4 сая төгрөг суулгахаар төсвийн саналыг хүргүүлээд байна.</p>	
Төрийн байгууллагуудын санал бус	<p>1. <u>Хил хязгааргүй алхам ТББ (2023.08.28):</u></p> <p>2023 оны улсын төсөвт 367 сая төгрөгийг батлуулсан. Салбар зөвлөлүүдийн болон Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлэж чадаагүй байна.</p>	



Иймд, 2024 онд улсын төсөвт 773,4 сая төгрөг болгож нэмэгдүүлэн суулгахаар төсвийн саналыг хүргүүлээд байна.

2. Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.30):

Төсвийн санал нь ОУИТБС-ын Ажлын албаны урсгал зардал, жил бүрийн нэгтгэл тайлангийн тулган баталгаажуулалт болон орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг багтаасан болно.

Гэхдээ эдгээрээс зөвхөн Ажлын албаны болон тулган баталгаажуулалтын зардлаас бусад зардал хасагддаг.

Тэрчлэн, жил бүр үндэсний зөвлөлөөс баталдаг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал төсөвт огт тусгадаггүй.

ТББ-ын үнэлгээ		<i>Ахиц дэвшил сул</i>
Хүрэх үе шат: Ил тод байдлыг хангах, эрдэс баялгийн салбарт бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах механизмыг бүрдүүлэх;		
Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Үул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар</u></p> <p>Иргэний нийгмийн оролцоог хангадаг гол бүтэц болох ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэхээр ажиллаж байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	<p>– <u>Хил хязгааргүй алхам ТББ (2023.08.28):</u></p> <p>Иргэний нийгмийн оролцоог хангадаг гол бүтэц болох ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд, орон нутгийн салбар зөвлөлд идэвхтэй иргэд, Төрийн бус байгууллагуудын төлөөлөл орж ажиллах боломжуудыг нээхээр ажиллаж байна.</p> <p><u>1. Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.30):</u></p> <p>Иргэний нийгмийн оролцоог хангадаг гол бүтэц болох ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд, орон нутгийн салбар зөвлөлд идэвхтэй иргэд, Төрийн бус байгууллагуудын төлөөлөл орж ажиллах боломжуудыг нээхээр ажиллаж байна.</p> <p>Эрдэс баялгийн салбарын бодлого, шийдвэр гаргахад иргэний нийгэм, олон нийт, уул уурхайн нөлөөлөлд өртөх</p>	

орон нутаг, иргэдийн оролцоо улам бүр хумигдсаар байна. Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар тогтоосон оролцооны зохицуулалтын хэрэгжилт эрдэс баялгийн салбарт улам бүр доройтож байна.


ТББ-ын үнэлгээ




Ахиц дэвшил сул


ЗОРИЛТ-2 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАМААР ТӨРӨӨС МЭДЭЭЛЭЛ АВАХ ИРГЭДИЙН ЭРХИЙГ БАТАЛГААТАЙ ХАНГАЖ, ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ

Хүрэх үе шат: Төрийн болон албаны нууцын жагсаалтыг мэдээллийн ил тод байдлын зорилгод нийцүүлэн өөрчлөх

Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр хийлгэж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хүлээн авсан. Хуулийн төслийг боловсруулж байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

Хүрэх үе шат: Цар тахал, хямралын үеийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах


Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай (Шинэчилсэн найруулга), Цахим гарын үсгийн тухай (Шинэчилсэн найруулга), Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай (Шинэчилсэн найруулга) хуулиуд 2021 оны 12 дугаар сард батлагдсан.</p> <p>Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2022-2023 онд “Ковид-19: Мэдэх эрх, сэтгүүлчийн ёс зүй” сэдвийн хүрээнд “Цар тахлын үеийн хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчийн ёс зүй”, “Ковид-19: Сэтгүүл зүйн үүрэг, ёс зүй, хамтын ажиллагаа”, “Цар тахлын үед аюулд өртөөд буй мэдэх эрх, үзэл бодлоо</p>	

	<p>илэрхийлэх эрх чөлөө: Олон улсын сургамж” зэрэг сэдэвт илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлсэн.</p>
<p>Төрийн бус байгууллагуудын санал</p>	<p><i>1. Хэвлэл мэдээллийн зөвлөл ТББ (2023.09.21):</i></p> <p>Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хямралын үеийн мэдээлэл харилцаа холбоог сайжруулах зорилгоор Төр-Иргэний нийгэм-Хэвлэл мэдээлэл гэсэн гурван талын оролцоотой мэдээлэл харилцааны бүлгийг үүсгэх туршилтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.</p> <p>2021-2023 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 17-р хороо, Сэлэнгэ аймагт тус бүр 9 хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлж нийт 27 хүнийг чадавхжуулсан.</p> <p>Энэхүү загвар туршлагыг ОБЕГ-ын бүтэц бүрэлдэхүүнд оруулж, Үндэсний хэмжээний хямралын үеийн мэдээлэл харилцааны бүлэг үүсгэх зорилго тавьсан хэдий ч хараахан биеллээ олоогүй байна.</p> <p>Иймд, цаашид энэ чиглэлд ажиллаж үр дүнд хүрэх шаардлагатай.</p> <p>Түүнчлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2022-2023 онд “Ковид-19: Мэдэх эрх, сэтгүүлчийн ёс зүй” сэдвийн хүрээнд “Цар тахлын үеийн хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчийн ёс зүй”, “Ковид-19: Сэтгүүл зүйн үүрэг, ёс зүй, хамтын ажиллагаа”, “Цар тахлын үед аюулд өртөөд буй мэдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө: Олон улсын сургамж” зэрэг сэдэвт илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлж оролцогч талуудыг мэдлэг, мэдээллээр хангаж ажилласан.</p>
<p>Хүрэх үе шат: Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэх эрхийг холбогдох хуульд нэмж оруулах</p>	
<p>Үнэлгээний дүн</p>	<p style="text-align: center;"></p> <p style="text-align: center;"><i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i></p>
<p>Үнэлгээг нотлох баримт</p>	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2021 оны 12 дугаар сард Улсын Их Хурлаас баталсан ба тус хуульд газрын хэвлийн баялагтай холбогдох дараах мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгохоор тусгасан.</p>


Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
<p>Хүрэх үе шат: Шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог хангахтай холбоотой Хууль тогтоомжийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, баримт нотолгоонд үндэслэн сайжруулах арга хэмжээний төсөл боловсруулж хэрэгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэгжилтийн үнэлгээ - Хэрэгжүүлэх 		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж 2023 оны 05 дугаар сард батлуулсан.</p> <p>Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж 2023 оны 05 дугаар сард батлуулсан.</p> <p>Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж 2022 оны 12 дугаар сард батлуулсан.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
<p>Хүрэх үе шат: Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоо, шууд хяналтыг хэрэгжүүлэх идэвх, санаачилгыг дэмжиж, олон нийтийн зөвлөлийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах;</p>		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 2023 оны 06 дугаар сард Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлагдсан.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

ЗОРИЛТ 3 – ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД СҮҮЛИЙН ҮЕИЙН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД ТУЛГУУРЛАН ХҮНИЙ ОРОЛЦООГ БАГАСГАХ, ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ


Хүрэх үе шат: Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар</u></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Үүнд хүний оролцоог багасгах, тендерт оролцогчийг нэг төрлийн баримт бичгийг тендер бүрд ирүүлэхгүй байх цахим мэдээллийн сан бүрдүүлэх; тендер шалгаруулалтын бүх үе шатыг ил тод болгох; ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийн үнэлгээ хийх тусдаа ажлын хэсэг байгуулах зэрэг заалтууд орсон.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	


Хүрэх үе шат: Цахим каталогийн системийн өгөгдлийг цуглуулж, ашиглалтад оруулах

Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар</u></p> <p>Цахим каталогийн системийн хөгжүүлэлтийг хийж дууссан, нэвтрүүлэхэд бэлдэж байна.</p>	



Хүрэх үе шат: Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын системүүдтэй ХҮР систем болон бусад арга хэлбэрээр холбох, мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар</u></p> <p>Төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” системээр дамжуулан тендерт оролцогчдын дараах мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтуудыг “Худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-д бодит цагийн горимоор татаж үнэлгээнд ашигласан ба 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 17,578 тендерийн урилга нийтлэгдэж 286,706 лавлагаа, тодорхойлолтыг цахим системээр лавласан байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

Хүрэх үе шат: Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах бүх захиалагч байгууллагын худалдан авах ажиллагааны гэрээний гүйцэтгэл, явцын мэдээллийг бүрдүүлж, OCDS форматаар нээлттэй түгээх;


Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар</u></p> <p>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах бүх захиалагч байгууллагын худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэсэн гэрээний гүйцэтгэл, явцын мэдээллийг OCDS форматаар нээлттэй түгээн ажиллаж байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

Хүрэх үе шат: Худалдан авах ажиллагааны хариуцлагын тогтолцоог төгөлдөржүүлж, RED FLAG INDICATOR бий болгох, олон нийтэд ил тод түгээх;


Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар</u></p> <p>Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр сүүлийн 5 жилд зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээлэл, худалдан авсан бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллүүдийг www.shilen.gov.mn цахим системд байршуулж, ил болгох ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран хийж байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
<p>Хүрэх үе шат: Захиалагч, тендерт оролцогч цахим системийн үйл ажиллагааг сурталчлан таниулж, хяналт сайжирсан эсэхэд судалгаа хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх;</p>		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар</u></p> <p>Худалдан авах ажиллагааны цахим системийн хэрэглэгчдэд албаны утсаар нийт 25,000 минут мэргэжил арга зүйн зөвлөгөө үйлчилгээг өдөр тутам утсаар үзүүлж, албаны it@procurement.gov.mn цахим шуудангаар ирүүлсэн 3,831 хүсэлтийг бүртгэн авч, тухай бүр шийдвэрлэн ажилласан байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	


ЗОРИЛТ 4 – ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙ, ТӨЛӨВШИЛ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХИЙГ ДЭМЖИЖ, ХАРААТ БУСААР БИЕ ДААН, ӨӨРИЙГӨӨ УДИРДАН ЯВУУЛАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛСЭН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Хүрэх үе шат: Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийн төрөөс хараат бус ажиллах орон зайг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт		<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл буюу Төрийн бус байгууллагын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д 2021 оны 11 дүгээр сард өргөн мэдүүлсэн.</p> <p>Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.</p>
Төрийн бус байгууллагуудын санал	<p>Санал ирээгүй.</p>	

Хүрэх үе шат: Иргэний нийгмийн суурь зарчим, үнэт зүйлсийг багтаасан Төр, иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод, иргэн болон ИНБ-ын оролцоотой явуулах

Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт		<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийг хангах Үндэсний хороо, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг 2023 оны 05 дугаар сард байгуулж, Төрийн болон иргэний нийгмийн түншлэлийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Монгол Улсын сайд, Засгийн</p>


		газрын Хэрэг эрхлэх газрын дарга Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг баталсан. Одоогоор төслийг УИХ-д өргөн барихаар бэлдэж байна.
Төрийн бус байгууллагуудын санал		Санал ирээгүй.
Хүрэх үе шат: Иргэний нийгмийн байгууллагын бүртгэлийн журмыг хялбаршуулж, цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт		<u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u> Улсын бүртгэлийн ерөнхий хуульд 2021 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт оруулж, Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг нээлттэй ил тод болгож www.opendata.burtgel.gov.mn сайтаас харах боломжийг бүрдүүлж, хөгжүүлэлтийг хийсэн.
Төрийн бус байгууллагуудын санал		Санал ирээгүй.
Хүрэх үе шат: Иргэний нийгмийн байгууллагын нээлттэй, ил тод байдлыг бий болгох хүрээнд мэдээллийн цахим санг үүсгэн ажиллуулах;		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт		<u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u> Улсын бүртгэлийн мэдээллийн санд сайжруулалт, хөгжүүлэлтийг хийж, Хуулийн этгээдийн дараах мэдээллийг ил тод нээлттэй болгосон байна: – хуулийн этгээдийн нэрийн сан; – хуулийн этгээдийн хаягийн сан; – хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг (эх)-ийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээлэл зэрэг болно.

Төрийн бус
байгууллагуудын санал


Санал ирээгүй.

ЗОРИЛТ 5 – НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХӨНДЛӨНГИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ

Хүрэх үе шат: Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд үр дүнгийн хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийлгэх

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт		<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам</u></p> <p>Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.</p> <p>Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2022 оны 12 дугаар сард эцэслэн батлагдсан.</p>
Төрийн бус байгууллагуудын санал		Санал ирээгүй..

Хүрэх үе шат: Нийтийн сонсголын тухай хуулийн хэрэгжилтэд Хууль тогтоомжийн хуульд заасан хяналт, үнэлгээ хийх

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт		<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам</u></p> <p>Холбогдох судалгаанд үндэслэн хуульд өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль 2023 оны 05 дугаар сард эцэслэн батлагдсан.</p> <p>1. <u>ХЗДХЯ (2023.08.30):</u></p>

ХЗДХЯ-аас боловсруулж байгаа хуулийн төслүүдэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана" гэж заасны дагуу УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.

Түүнчлэн Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд холбогдох эрх зүйн актад заасны дагуу хяналт тавьж, үнэлгээ хийх ажлыг тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хэрэгжүүлэн ажиллаж байна.

<p>Төрийн бус байгууллагуудын санал</p>	<p>Санал ирээгүй.</p>
--	-----------------------

Хүрэх үе шат: Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд Хууль тогтоомжийн хуульд заасан хяналт, үнэлгээ хийх

<p>Үнэлгээний дүн</p>		<p><i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i></p>
------------------------------	---	--

<p>Үнэлгээг нотлох баримт</p>	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам</u></p> <p>Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан байна.</p> <p>Хог хаягдлын тухай хуульд 3 давхардал, 6 зөрчил, 22 хийдэл тогтоогдсон.</p> <p>Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд хог хаягдлын салбарт эрх зүйн зохицуулалтын хувьд ахиц дэвшил гарсан ч практик хэрэгжилт хангалтгүй байна.</p>
--------------------------------------	---

	Иймд, төрийн төв болон нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллагын эрх, үүргийг хуульчилсан хэм хэмжээг оновчтой томъёолох, хог хаягдлын менежментийн эрх зүйн зохицуулалт, удирдлагын чиг үүргийг тодорхой болгох шаардлагатай хэмээн дүгнэж байна.	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
Хүрэх үе шат: Хяналт үнэлгээний дүнг нийтэд болон шийдвэр гаргагч нарт танилцуулж, сайжруулах арга хэмжээний төсөл боловсруулах		
Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам</u> Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг гарган ирүүлэхийг Аймаг, нийслэл, Засаг дарга нарт албан бичгийг хүргүүлээд байна.	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
Хүрэх үе шат: Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам</u> Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
Хүрэх үе шат: Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам</u>	

	Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.
--	--

Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.
----------------------------------	----------------

Хүрэх үе шат: Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
----------------	---	---

Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам</u></p> <p>Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 01 дүгээр сард Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сард хуулийн төслийг эцэслэн баталсан.</p>
------------------------	--

Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.
----------------------------------	----------------

Хүрэх үе шат: Шинэчлэгдсэн хууль тогтоомжийг таниулах, сурталчлах

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
----------------	---	---

Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам</u></p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг батлагдсанаас хойш байгууллагуудын захиалгаар сургалт хийж, түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио, подкастаар мэдээлэл хийж, сурталчлан таниулсан.</p>
------------------------	---

Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.
----------------------------------	----------------

ЗОРИЛТ 6 – УЛСЫН ТӨСӨВ, ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Хүрэх үе шат: Монгол Улсын төсөв, хөрөнгө оруулалт, тусгай сангууд, зээл тусламж, төсөл хөтөлбөрийн төлөвлөлтөөс эхлээд хэрэгжүүлж дуусах бүхий л үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтыг төсвийн хууль тогтоомжид оруулах, үүний тулд одоо байгаа зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тэдгээрийг хэрхэн боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий зөвлөлдөх механизмыг талуудын оролцоотойгоор ажиллуулж үр дүнд хүрэх

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам</u></p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд иргэд олон нийтэд зориулсан www.publicinvestment.gov.mn цахим сайт, гар тасны аппликэйшн шинэчлэн сайжруулсан:</p> <ul style="list-style-type: none"> - Төслүүдийн илүү олон мэдээллийг нээлттэй болсон. - Санхүүжилтийн түүхийг, процессын хамт илүү дэлгэрэнгүй харуулдаг болсон. - Ашиглалтад орсон төслүүдийн мэдээллийг ил тод болсон. - Иргэд ямар төслүүд хэзээ ашиглалтад орсон эсэх, хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч, хянагч байгууллагууд болон төсөвт өртгийн мэдээллийг хянах боломжтой болсон. 	
ТББ-ын үнэлгээ		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээ үндэслэл	<p><u>Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.31):</u></p> <p>Шилэн дансны тухай хууль, журамд тусгай сангууд, зээл тусламж, төсөл хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийн ил тод, иж бүрэн байдлыг хангах зохицуулалт тусаагүй байгаа.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон нийтээс санал авахаар Сангийн яам 2022.01.05-нд сайтдаа байршуулсан.</p>	

Уг хуулийн төсөл нь 2022 онд УИХ-аас хэлэлцэх хуулиудын жагсаалтад багтсан байсан боловч УИХ-д хуулийн төсөл өргөн баригдаагүй байна.

Шилэн дансанд төсвийн зарцуулалттай холбогдох шийдвэрийн нээлттэй байдал сул байгааг анхаарах хэрэгтэй байна. Ялангуяа нийслэл, дүүргийн төсвийн шийдвэрүүдийн ил тод байдал нэн сул байна.

Шилэн дансны цахим хуудсыг шинэчлэхдээ өмнө байсан мэдээллийг устгахгүйгээр архив хэлбэрээр нийтэд ил байлгах шаардлагыг хууль, журамд тусгах хэрэгтэй.

Ер нь цахим хуудаснуудыг шинэчлэхдээ өмнө байсан мэдээллийг устгахгүйгээр архив хэлбэрээр нийтэд ил байлгадаг болох хэрэгтэй байна.

www.publicinvestment.gov.mn/projects хуудсанд зөвхөн 2022 оноос хойших төслүүдийн мэдээлэл л орсон байна. Иймд өмнөх жилүүдийн төслийн мэдээллийг мөн оруулах хэрэгтэй байна.

www.publicinvestment.gov.mn гар утасны аппликэйшнийг албан ёсоор хэрэглэх шийдвэрийг СаЯ гаргах хэрэгтэй байгаа.

"Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем /ODAMIS/"-ийн тухайд:

Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдлын судалгааг "Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв" ТББ хийж гүйцэтгэсэн.

Шилэн дансны мэдээлэл болон Сангийн яамнаас хөгжүүлсэн "Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем" дэх мэдээлэлд үндэслэн судлахад гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй байгаа нь харагдлаа.

Тухайлбал, судалгаанд гадаадын зээл, тусламжийн 109 төсөл, арга хэмжээг хамруулснаас 2018-2021 онд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн дунджаар 60 гаруй хувийг Шилэн дансны системд нийтэлсэн байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний удирдлагын мэдээллийн системийн мэдээллээс үзэхэд төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж

буй ажлууд нь хийгдээд дууссан эсэх, ямар төсөв хөрөнгө зарцуулагдсан, хэр чанартай гүйцэтгэсэн зэргийг нэгтгэсэн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлагнахгүй байна.

Хүрэх үе шат: Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журамд батлагдсан төсвийн тоон мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар ил болгох зохицуулалт оруулах

Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
----------------	---	------------------------



<p>Үнэлгээг нотлох баримт</p>	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам</u></p> <p>Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг шинэчлэхтэй холбоотой иргэд, хуулийн этгээд, иргэний нийгмийн болон олон нийтийн байгууллагуудтай цуврал хэлэлцүүлэг зохион байгуулснаас гадна 1600 гаруй оролцогчдыг хамруулан судалгаа авсан.</p> <p>Дээрх судалгааны үр дүнгүүд болон ажлын хэсгийн дүн шинжилгээнд үндэслэн Шилэн дансны тухай хууль, журмын төслийг боловсруулж, эрхзүйн орчны шинжилгээ хийсэн.</p>
--------------------------------------	---

ТББ-ын үнэлгээ		<i>Огт эхлээгүй эсвэл ноцтой саатсан</i>
----------------	---	--


<p>Үнэлгээ өгсөн үндэслэл</p>	<p><u>Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.31):</u> Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журамд батлагдсан төсвийн тоон мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар ил болгох зохицуулалт ороогүй.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон нийтээс санал авахаар Сангийн яам 2022.01.05-нд сайтдаа байршуулсан.</p> <p>Уг хуулийн төсөл нь 2022 онд УИХ-аас хэлэлцэх хуулиудын жагсаалтад багтсан байсан боловч УИХ-д хуулийн төсөл өргөн баригдаагүй байна.</p>
--------------------------------------	---

Хүрэх үе шат: Shilendans.gov.mn сайтыг шинэчлэхдээ төсвийн хэрэгжилт, ил тод байдлыг хангахад ашиглагдаж буй систем хоорондын уялдааг хангах, талуудын оролцоог тэгш хангаж санал солилцох, судалгаан дээр тулгуурлан хөгжүүлэх

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
----------------	---	---


<p>Үнэлгээг нотлох баримт</p>	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам</u></p> <p>Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлж, 2023 оны 1 дүгээр сард нэвтрүүлсэн. Шинэчилсэн системд нийт 6058 байгууллага, 10,000 гаруй хэрэглэгч бүртгүүлсэн байна.</p> <p>Системийн шинэчлэлийн гол давуу тал нь Сангийн яамны төсөв, санхүүгийн системүүд болон бусад томоохон систем, мэдээллийн сантай шууд холбож мэдээлэл оруулах гар ажиллагааг хөнгөвчлөх, мөн үнэн зөв, ойлгомжтой мэдээллийг олон нийтэд хүргэх боломжийг бүрдүүлээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан; - Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл; - Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээ буюу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний ерөнхий мэдээлэл; - Байгууллагын бүртгэлийн ерөнхий мэдээлэл; - Байгууллагын дансны мэдээлэл. 	
<p>ТББ-ын үнэлгээ</p>		<p><i>Ахиц дэвшил сул</i></p>
<p>Үнэлгээ өгсөн үндэслэл</p>	<p><u>Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.31):</u> Шилэн дансны шинэ цахим хуудаст 2023 оны мэдээлэл л орсон байна. 2023 оноос өмнөх мэдээлэл орох эсэх нь тодорхойгүй байна.</p> <p>2022 он хүртэлх төсвийн мэдээлэл бүхий ХУУЧИН ШИЛЭН ДАНС (old.shilendans.gov.mn) хуудас 2023.08.28-нд нээгдэхгүй байснаа маргааш нь нээгдэж байна. Төсвийн ил тод байдлыг хангахын тулд ХУУЧИН ШИЛЭН ДАНС-ыг устгахгүй нээлттэй байлгах хэрэгтэй.</p> <p>Ер нь цахим хуудаснуудыг шинэчлэхдээ өмнө байсан мэдээллийг устгахгүйгээр, архив хэлбэрээр нийтэд ил байлгадаг болох хэрэгтэй байна.</p>	
<p>Хүрэх үе шат: Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд жилийн турш саналаа өгч болох цахим талбар бий болгох</p>		
<p>Үнэлгээний дүн</p>		<p><i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i></p>
<p>Үнэлгээг нотлох баримт</p>	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам</u></p> <p>www.iltod.mof.gov.mn цахим системд "Иргэдийн оролцоо" цэс шинээр хөгжүүлэлт хийгдэн 2023 оны 2 дугаар сард</p>	

	<p>ашиглалтад орсон ба "Санал асуулга" дэд цэс тусламжтайгаар жилийн турш иргэд олон нийтээс санал авах боломжтой болсон.</p> <p>Мөн "Хэлэлцүүлэг" дэд цэсийн тусламжтайгаар төсвийн тухай хууль, журам болон төсөвтэй холбоотой аливаа асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой цахим талбарыг нэмэлтээр хөгжүүлэн ашиглалтад оруулсан.</p> <p>Иргэд Сангийн яамны "төсвийн хөрөнгө оруулалт" гар утасны аппликэйшнээр дамжуулан 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн саналд өөрийн харьяа сум, дүүрэг, аймгийнхаа хөрөнгө оруулалтад саналаа өгөх боломж бүрдүүлсэн.</p>	
ТББ-ын үнэлгээ		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээ өгсөн үндэслэл	<p><u>Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.31)</u>: Батлагдсан төсвийн зарцуулалтын явцад иргэд жилийн турш саналаа өгч болох цахим талбар бий болоогүй байгаа (shilendans.gov.mn-д иргэд санал өгөх цэс байхгүй байна).</p> <p>Хүрэх үе шат: Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд өгсөн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэд цахим платформуос харах боломжтой болгох</p>	
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Сангийн яам</u></p> <p>Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн өгсөн саналыг хэрхэн шийдвэрлэсэн тухай үр дүнгийн тайлан бэлтгэн "Иргэдийн төсөв" цахим систем болон Сангийн яамны цахим хуудсанд байршуулан түгээх боломжтой.</p>	
ТББ-ын үнэлгээ		<i>Огт эхлээгүй эсвэл ноцтой саатсан</i>
Үнэлгээ өгсөн үндэслэл	<p><u>Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.31)</u>: Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд өгсөн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэд цахим платформуос харах цэс хийгдээгүй байна.</p> <p>Хүрэх үе шат: Төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn сайт дахь хайлтын системд төслийг "эхлэх огноо"-оор нь хайлт хийх сонголт оруулах</p>	
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>


<p>Үнэлгээг нотлох баримт</p>	<p><u>Хэрэгжүүдсэн байгууллага: Сангийн яам</u></p> <p>Төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn цахим сайт дахь хайлтын системд төслийг "эхлэх огноо"-оор нь хайлт хийх сонголт оруулан шинэчлэн сайжруулалт хийсэн.</p>	
<p>ТББ-ын үнэлгээ</p>		<p><i>Ахиц дэвшил сул</i></p>
<p>Үнэлгээ үндэслэл өгсөн</p>	<p><u>Нээлттэй нийгэм форум ТББ (2023.08.31):</u> www.publicinvestment.gov.mn/projects хуудсанд зөвхөн 2022 оноос хойших төслүүдийн мэдээлэл л орсон байна.</p> <p>Иймд, өмнөх жилүүдийн төслийн мэдээллийг мөн оруулах хэрэгтэй байна.</p>	

ЗОРИЛТ 7 – ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ, ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ


Хүрэх үе шат: Эмийн зохистой хэрэглээний талаар олон нийтэд хүргэх мэдээллийн үндсэн агуулгыг боловсруулж, мэдээлэл, сурталчилгаа хийх

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар</u></p> <p>Эмийн зохистой хэрэглээний талаар олон нийтэд хүргэх мэдээллийн үндсэн агуулгыг иргэд, эм зүйч, эмч гэсэн чиглэлийн хүрээнд боловсруулж, цахим хуудас, сургалт, шууд бичлэг, зурагт хуудас, видео контент, сургалт, телевизийн ярилцлагаар дамжуулан хүргэлээ.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	


Хүрэх үе шат: Эмийн үнийн эрх зүйн орчны үнэлгээг хийж, хууль эрх зүйн баримт бичигт үнийн зохицуулалтын талаар өөрчлөлт оруулах

Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар</u></p> <p>Ажлын хэсэг эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ бүрдэлт, чанар, зохистой хэрэглээний өнөөгийн байдал, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт, үнэлгээ хийсэн. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

Хүрэх үе шат: Хөнгөлөлттэй үнээр олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг боловсруулахад ашиглах гадаад, дотоодын жишиг үнийг тогтоодог болох


Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар</u></p> <p>Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд эмийн гадаад, дотоодын жишиг үнэ ашигладаг болох зохицуулалтыг (эмийн үнийн даатгал) тусгаж байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

Хүрэх үе шат: Эмийн зохицуулалтын болон Гаалийн ерөнхий газрын цахим мэдээний сангийн мэдээллийг ашигладаг болох


Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар</u></p> <p>Импортын эмийн үнийн мэдээллийг Гаалийн ерөнхий газраас албан бичгээр тухай бүр авч байгаа ба мэдээлэл солилцох, хамтран ажиллах тухай гэрээ байгуулахаар гэрээний төсөл дээр талууд ажиллаж байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

ЗОРИЛТ 8 – ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ


Хүрэх үе шат: Үүрэг амлалтын хэрэгжилтийг хангах ажлын хэсэг байгуулах

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u> Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2020 оны 12 дугаар сард байгуулагдсан.	
Төрийн байгууллагуудын санал	<u>Хэвлэл мэдээллийн зөвлөл ТББ (2023.09.21):</u> Ажлын хэсэг ямар бүрэлдэхүүнтэй байгаа болон тус ажлын хэсэг ажилласан эсэх нь тодорхойгүй.	


Хүрэх үе шат: Үүрэг амлалтад дурдсан хууль эрх зүйн зохицуулалтад үнэлгээ хийх, үр дүнг оролцогч талуудад танилцуулах



Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u> Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг хийж, үр дүн, зөвлөмжийг ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн болно.	
Төрийн байгууллагуудын санал	<u>Хэвлэл мэдээллийн зөвлөл ТББ (2023.09.21):</u> Хаанаас, ямар судалгаа хийсэн, уг судалгаа нь хэр үндэслэлтэй, хараат бус байж чадах эсэх, мөн гол зөвлөмжийг тодруулж оруулах; Түүнчлэн Хэвлэл мэдээллийн аливаа зохицуулалт нь хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлын зарчмыг хангах буюу хэвлэл мэдээлэл нь төрийн шууд ба шууд бус цагдан хяналтаас ангид байх, редакцын хараат бус байдал хангагдсан байхад чиглэх ёстойг онцлон тэмдэглэх. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгад хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын талаар тусгахдаа салбарын өргөн хэлэлцүүлэг, ойлголцолд хүрэх шаардлагатай.	

Хүрэх үе шат: Үүрэг амлалтад дурдсан хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах олон улсын хэм хэмжээг судлах, нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулах

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд олон улсын эрх зүйн зохицуулалтыг судалж, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагыг тусгайлан хуульчилсан Солонгос, Дани, Ирланд, Энэтхэг, Люксембург зэрэг улсын туршлагыг сонгон авч судалж байна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	<p><u>Хэвлэл мэдээллийн зөвлөл ТББ (2023.09.21):</u> Эдгээр нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын жишиг туршлага болохуйц улс орнууд биш тул сонголтыг дахин сайжруулж судлах шаардлагатай.</p> <p>Иргэдийн оролцоо төслөөс хийсэн “Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь” судалгаанд Норвеги, Австрали, Их Британи, БНСУ, АНУ, Латви, Литви, Чех гэсэн улсын туршлагыг судалсан байсан.</p> <p>Түүнчлэн Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын жишиг туршлагуудыг судлахдаа Европын хараат бус хэвлэл мэдээллийн зөвлөлүүдийн гишүүн орнууд болох ХБНГУ, Бельги, Ирланд, Дани, Гүрж, Босни-Херцеговин зэрэг улсын туршлагыг судалсан.</p> <p>Эдгээр улсуудын туршлагад тулгуурлан Хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагыг 2015 оны эхээр Хэвлэл мэдээллийн зөвлөл нэртэйгээр байгуулж 8 жилийн турш үйл ажиллагаа нь тасралтгүй бөгөөд үр дүнтэй хэрэгжиж байгаа.</p> <p>Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл нь салбарын сайн дурын санаачилгаар үүсэж хөгжсөн, хараат бус бие даасан үйл ажиллагаагаараа Төв Ази болон Зүүн Европын орнуудад сайн туршлагаар нэрлэгдэж буй юм.</p>	
Хүрэх үе шат: Холбогдох хуулийн нэмэлт өөрчлөлтөд иргэд, олон нийт, оролцогч талуудын санал авах		


Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
----------------	---	---

<p>Үнэлгээг нотлох баримт</p>	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хувилбарт санал авахаар ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн.</p> <p>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сэтгүүл зүйн салбарын гол холбоод болох “Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл” ГҮТББ, “Хэвлэл мэдээллийн зөвлөл” НҮТББ зэрэг сэтгүүл зүйн салбарын мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл байх бөгөөд тус байгууллагуудаас тухай бүр санал авч байна.</p>	
<p>Төрийн бус байгууллагуудын санал</p>	<p><u>Хэвлэл мэдээллийн зөвлөл ТББ (2023.09.21):</u></p> <p>Дээр нэр дурдсан хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн байгууллагууд холбогдох хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд эрс шүүмжлэлтэй хандсан бөгөөд уг шүүмжийг ХЗДХЯ тусгасан эсэх нь тодорхойгүй тул өнөө хүртэл нэгдсэн ойлголцолд хүрээгүй, хуулийн төслийг бэлтгэх үйл явц удааширч саатсан.</p> <p>Жишээлбэл, Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2020 оны 03 дугаар сард “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан ‘Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт’ гэсэн бүлэг дэх заалтууд нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын мөн чанарыг үгүйсгэсэн, ‘өөрийн зохицуулалт’ нэрээр Монголын бүхий л хэвлэл мэдээллийн байгууллагуудыг төрийн хяналтад оруулж, сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүйн асуудлыг төрийн оролцоотой шийдэх гэсэн оролдлогыг илэрхийлсэн, олон улсын тавцанд ардчилсан Монгол Улсын нэр хүндийг сэвтээсэн, хэвлэлийн эрх чөлөөний индексийг бууруулсан үйлдэл болно гэж үзэж байна” гэж шүүмжилсэн байр суурь бүхий албан тоотыг хүргүүлсэн.</p>	
<p>Хүрэх үе шат:</p>	<p>Хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг эцэслэн боловсруулж өргөн барих. Лобби үйл ажиллагаа зохион байгуулах.</p>	
<p>Үнэлгээний дүн</p>		<p><i>Ахиц дэвшил сул</i></p>
<p>Үнэлгээг нотлох баримт</p>	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг авч ажиллана.</p>	



Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
Хүрэх үе шат: Сэтгүүлч эх сурвалжаа нууцлах баталгааг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд тусгах		
Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг мэдээллийн нууц эх сурвалжаа илчлэхийг шаардахыг хориглох тухай зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан болно.</p> <p>Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг авч ажиллана.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
Хүрэх үе шат: Төрийн болон албаны нууцын тухай хуулийг өөрчилж Засгийн газрын тогтоол, төрийн байгууллагын шийдвэрээр бус зөвхөн хуулиар төрийн нууцын жагсаалтыг батлах		
Үнэлгээний дүн		<i>Ахиц дэвшил сул</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам</u></p> <p>Тагнуулын Ерөнхий газрын саналыг хүлээн авсны дараа Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны “Жагсаалт батлах тухай” А/28 дугаар тушаалд өөрчлөлт оруулна.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

ЗОРИЛТ 9 – ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛЖ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ

Хүрэх үе шат: Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-аар үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, илүү хялбар болгох

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Цахим хөгжил, харилцаа холбооны яам</u></p> <p>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д:</p> <p>2020 онд 23 байгууллагын 181 үйлчилгээ, 2021 онд 59 байгууллагын 606 үйлчилгээ, 2022 онд 69 байгууллагын 897 үйлчилгээ, 2023 оны 07 дугаар сарын байдлаар 83 байгууллагын 994 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж, нийт 32,962,024 удаагийн хандалт бүртгэгдсэн байна.</p> <p>Түүнчлэн тус системд 1,641,523 буюу насанд хүрсэн иргэдийн 74% нь бүртгүүлж, 397 мянган хэрэглэгч идэвхтэй ашиглаж байна.</p> <p>“E-Mongolia 3.0” хувилбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ID-ийг нэмж, сул хараатай иргэдэд зориулан өнгөний контрастыг нэмэгдүүлэх, өөрчлөх, шөнийн горимд шилжих боломжтой дэлгэцийн шинэчлэлийг хийж, үсгийн фонтоо хэмжээг өөрийн хэрэгцээнд тааруулан ихэсгэж, багасгах боломжийг бүрдүүлсэн зэрэг олон шинэчлэл хийгдсэн</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	

Хүрэх үе шат: Иргэдээс төрийн үйлчилгээний хүнд суртал, шат дамжлага бусад хүндрэлийн талаар мэдээлэл авах цахим цонхыг “E-Mongolia” системд байршуулах

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Цахим хөгжил, харилцаа холбооны яам</u></p> <p>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д серверийн өргөтгөл, программ хангамжийн сайжруулалт хийж, хэрэглэгчдэд богино хугацаанд нэгэн зэрэг мэдээлэл, мэдэгдэл илгээх боломжтой мэдэгдэл хүргэх систем "push notification"-ийг хөгжүүлсэн.</p> <p>Мөн "Авлигатай тэмцэх газарт өргөдөл гомдол гаргах" цэсийг шинээр нэмж, E-Mongolia системээс Иргэд, олон нийттэй харилцах 11-11 дугаарт дуудлага хийх нөхцөлийг бүрдүүлсэн.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
<p>Хүрэх үе шат: Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээний мэдээлэл, татвар төлөлт, урамшууллын мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлэх</p>		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Цахим хөгжил, харилцаа холбооны яам</u></p> <p>E-Mongolia платформ нь хэрэглэгчийн хандалт, сүлжээний урсгал, ачаалал зэргээ хянаж ачаалал ихтэй үед ухаалгаар өөрийгөө өргөтгөж, ачаалал буурсан үед буцаж багасгах чадвартай AI (хиймэл оюун ухаан) дээр суурилсан функц бүхий динамик шийдэл нэвтрүүлсэн.</p> <p>Ингэснээр платформ үр ашигтайгаар ажиллаж, олон төрлийн хэмнэлт хийхээс гадна илүү хурдтайгаар нэг агшинд 2 сая хэрэглэгчийн ачааллыг тэнцвэржүүлэх боломжтой болсон.</p> <p>Иргэн өөрийн фейсбүүк хаяг, үндэсний и-мэйл, E-Mongolia аппликэйшний "push notification", хувийн мэйл хаягуудаас сонгон баримт бичгийн хугацаа дууссан сонордуулга, төлбөрийн нэхэмжлэх болон төрийн үйлчилгээний мэдэгдлийг шууд хүлээн авах, зөрчилтэй жолооны үнэмлэх болон хугацаа дууссан бичиг баримтуудын анхааруулах мэдээллийг хүргэж байна.</p>	

Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.
----------------------------------	----------------

Хүрэх үе шат: Төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг тогтмол хангах, тухай бүр шинэчлэх, иргэд, олон нийттэй харилцах төвийн “1111” тусгай дугаараар төрийн байгууллагын хүнд суртал, авлигын шинж чанартай гомдол, мэдээллийг хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагааг сайжруулах

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
----------------	---	---



Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Цахим хөгжил, харилцаа холбооны яам</u></p> <p>Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia системд "Авлигатай тэмцэх газарт өргөдөл гомдол гаргах" цэсийг шинээр нэмж, хөгжүүлсэн.</p> <p>E-Mongolia системээс Иргэд, олон нийттэй харилцах 11-11 дугаарт дуудлага хийх нөхцөлийг бүрдүүлсэн.</p>
------------------------	--

Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.
----------------------------------	----------------

Хүрэх үе шат: “1111” тусгай дугаарт ирсэн мэдээлэл, түүнд хариу өгсөн, гомдол барагдуулсан талаарх тайланг сар бүр гаргаж, холбогдох төрийн байгууллагуудад хүргэх, Засгийн газрын вэбсайт дээр энэхүү тайлан мэдээллийг байршуулах

Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
----------------	---	---

Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Цахим хөгжил, харилцаа холбооны яам</u></p> <p>Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 2022.01.01-ний өдрөөс 2023.08.01-ний өдөр хүртэлх хугацаанд 255,284 иргэн утас, веб хуудас, дуут шуудан, фейсбүүк, и-мэйл, биечлэн, И-Монголиа зэрэг сувгаар хандсан байна.</p> <p>Үүнээс уг сувгуудаар дамжуулан ирүүлсэн 95,750 санал, хүсэлт, гомдлыг бүртгэж Засгийн газрын яам, агентлаг, аймаг, нийслэлийн шилжүүлсэн байна.</p> <p>Өдөр тутмын болон 7 хоногийн тайлан мэдээг Ерөнхий сайдын Ажлын албанд хүргүүлж, төвийн албан ёсны хуудсаар олон нийтэд тогтмол мэдээлж байна.</p>
------------------------	---

Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
Хүрэх үе шат: Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн стандарт боловсруулж, батлуулах		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Цахим хөгжил, харилцаа холбооны яам</u></p> <p>“Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих ерөнхий шаардлага” стандартын төслийг боловсруулж, Техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн, Стандарт, хэмжил зүйн газрын 2022 оны С/51 тушаалаар MNS 6984:2022 стандартыг батлуулсан.</p>	
Төрийн бус байгууллагуудын санал	Санал ирээгүй.	
Хүрэх үе шат: Арга хэмжээ болгох - том төрөөс ухаалаг төр рүү шилжих, улмаар иргэн төвтэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх		
Үнэлгээний дүн		<i>Бүрэн хэрэгжсэн эсвэл Ахиц дэвшил сайн</i>
Үнэлгээг нотлох баримт	<p><u>Хэрэгжүүлсэн байгууллага: Цахим хөгжил, харилцаа холбооны яам</u></p> <p>И-Бизнес (e-business) платформд хуулийн этгээдтэй холбоотой 417 тусгай зөвшөөрөл, 42 лавлагаа тодорхойлолт, 226 төрийн үйлчилгээ буюу нийт 685 үйлчилгээг нэвтрүүлсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах, хуулийн этгээдийн нэр авах, улсын бүртгэлд бүртгүүлэх, эд хөрөнгийн жагсаалтаа бүртгүүлэх, цахим гэрчилгээ авах, тамганы хяналтын хуудас илгээх зэрэг үйл явцыг цахимаар шийдэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>www.lavlagaa.e-mongolia.mn системд 81 лавлагаа тодорхойлолтыг хүн хуулийн этгээдэд олгож байна.</p> <p>Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (www.opendata.gov.mn)-ийг хөгжүүлж, 57 байгууллагын 701 нээлттэй өгөгдлийг бүрдлийг байршуулаад байна.</p> <p>Төрийн үйлчилгээний ХУРДАН цэгийг дотоод болон гадаадад нээж, интернэт холболтгүй иргэдэд биечлэн үйлчилгээ үзүүлж байна.</p>	

www.huduu.mn сайтыг ашиглалтад оруулж, 21 аймгийн мэдээлэл, ажлын байр, засаглал, дэд бүтэц, эдийн засаг, байгаль орчин, санхүү, боловсрол, эрүүл мэнд, бизнесийн орчин, тэдгээрийн давуу тал бүхий өрсөлдөх чадварын индексийг байршуулаад байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төрийн захиалгаар хийгдсэн бүх төрлийн судалгааг нэг дор төвлөрүүлж, хялбар хайж олох, давхцал хянах, үнэлгээ болон санал шүүмж өгөх, цаашдын судалгаа, бодлого төлөвлөлтөд ашиглах зорилготой төрийн их өгөгдөл бүрдүүлэх, бодлого, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлсэн судалгааны нэгдсэн платформ (www.sudalгаа.gov.mn)-ыг хөгжүүлсэн. Тус платформд 76 байгууллагын 1010 судалгаа байршсан байна.

**Төрийн бус
байгууллагуудын
санал**

Санал ирээгүй.

СУРГАМЖ

Үндэсний үйл ажиллагааны IV төлөвлөгөөг хамтран бүтээх үйл явц нь олон талыг оролцуулж, идэвхтэй өрнөсөн ч албан ёсоор 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2023 оны 6 дугаар сар хүртэл ердөө 1.5 жилийн хугацаа байсан. Нийт 9 зорилт буюу зорилтод хүрэх 53 үе шатны 25 нь хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх томоохон зорилт байв.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэ хуулийн төсөл боловсруулах нь судалгаа, үнэлгээ, боловсруулалтыг багтаасан удаан хугацаа шаарддаг процесс юм.

Мөн олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, Байнгын хороодод өргөн мэдүүлэх, Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх зэрэг тодорхой журмын дагуу явагддаг бөгөөд үе шат тус бүрд шаардлагатай засваруудыг хийдэг. Бид энэ сургамжийг тавдугаар ҮАҮТ-г төлөвлөхдөө авч үзэх болно.

Өөр нэг сорилт бол боловсон хүчний өөрчлөлт, НЗТ-ийн үүрэг хариуцлага нэг төрийн байгууллагаас нөгөөд шилжих явдал байв. Энэ нь шинэ яам, ажилтнуудад НЗТ-ийн үзэл баримтлалтай танилцаж, үр дүнтэй хэрэгжилтийг хангахад цаг хугацаа хэрэгтэй байгааг харууллаа.

СУРГАМЖ

Гэсэн хэдий ч богино хугацаанд зорилтот хүрэх 39 (74%) үе шатыг бүрэн хэрэгжүүлсэн, 14 (26%) үе шат ахиц дэвшил гаргасан байна. Бидэнд огт эхлээгүй эсвэл ноцтой саатсан үе шат байхгүй.

Хил хязгааргүй алхам ТББ (2023.08.28):

Олон талын оролцоотой боловсруулсан дөрөвдүгээр ҮҮАТ амжилттай боловсруулсантай адил хэрэгжүүлэх үйл явцад талуудын оролцоог тогтмол, жигд хангахад үйл ажиллагааны хувьд тасалдал үүссэн, зарим талаар зогсонги байдал үүссэн. Ялангуяа, хувийн хэвшлийн, хэвлэл мэдээллийн болон орон нутгийн, алслагдсан дүүрэг хорооны иргэдийн оролцоо тэдний үүрэг хариуцлагыг тодорхой болгож чадаагүй. НЗТ-ийн талаарх орон нутгийн төрийн албан хаагчдын мэдлэг ойлголт, үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд арга хэмжээ аваагүй болно.

ЗӨВЛӨМЖ

Хараат бус тайлагналын механизмаас 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын тавдугаар ҮАҮТ төлөвлөлтийн явцад анхаарах зөвлөмжүүдийг гаргасан бөгөөд бид энэхүү шинэ мэдээлэл болон НЗТ-ийн 2023-2028 оны стратегийн зөвлөмжийг дагаж мөрдөх болно.

Бид иргэний нийгмийн төлөөлөлтэй үргэлжлүүлэн хамтран ажиллаж, төлөвлөлтийн талаар ярилцах тогтмол уулзалтуудыг зохион байгуулж, асуудлыг хамтдаа шийдвэрлэхийг эрэлхийлэх болно.

Мөн бид тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд Засгийн газрын оролцогч талууд, холбогдох яамдтай зорилтот уулзалтуудыг төлөвлөнө. Төлөвлөлтийн явцад бид тавдугаар ҮАҮТ-ний мэдээллийг цаг тухайд олон нийтэд хүргэх бөгөөд бүх оролцогч тал ирээдүйн амлалтаа илүү тодорхой, шинэлэг зорилгуудаар төлөвлөж хэрэгжүүлэхийн төлөө ажиллах болно.

1. Хил хязгааргүй алхам ТББ (2023.08.28):

Бүх түвшинд салбар дундын мэдээлэл солилцоо, ажлын уялдааг хангахад онцгойлон анхаарч ажиллах.

2. Сэтгэлзүйн мэдрэмж ТББ (2023.09.01):

ЗӨВЛӨМЖ

Энэ өдрийн мэнд хүргэе! НЗТ-ийн төлөвлөгөө, тайлантай танилцлаа. Төлөвлөгөө нь биелэлтээ дүгнэх үзүүлэлтүүд байхгүй, ТХЗ-ийн үзүүлэлтүүдтэй уялдаа холбоо байгаа гэж хэт ерөнхий бичсэнээс нотлох баримтууд хангалтгүй, ихэвчлэн хүүрнэх өгүүлбэрээр нэг хүний бодол санааг гаргаад бичсэн мэт сулхан тайлан санагдаж байна. Хэрэглэгч талаас нь харвал жаахан итгэл үнэмшил тааруу гэмээр...

Зарим зорилтын биелэлтийг нэн ялангуяа ТХЗ-ийн ҮСДИ-ийн хоёр дахь илтгэлд дурдсан ижил төстэй (ТХЗ-16 -ийн targets)/ биелэлтийг мэдээллийн эх үүсвэр болгож бичвэл гэсэн бодол төрлөө.

Монгол Улсын НҮБ-д 2023 оны 07 сард тайлагнасан ҮСДИ-ийн хоёр дахь илтгэл өмнөхөөсөө нэлээд сайжирч бичсэн, статистик үзүүлэлтүүдээр зарим прогресс харуулсан гэж харсан. Гэхдээ ямартай ч тайлан бичээд явуулах болсонд талархаж байна.

МАСАМ 2 хөтөлбөрийн хүрээнд сайхан ажлууд хийсэн тайлан мэдээлэл манай Цэрэнпүрэв хуваалцаж байсан. Түүнийг мөн олж харах боломж олгосон Болорсайханд баярлалаа. Энэ Засгийн газарт ахиц дэвшил байгаад талархаж байдаг шүү. Нээлттэй ил тод, иргэдийн оролцоог хангаад засаад сайжруулаад явахад амжилт ирнэ дээ.

----oOo----